

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эми Чой
2023 оны 2 дугаар улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Эми Чой миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2023 оны 2 дугаар улирал] (“Тайлант хугацаа”).

1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Хамрах хугацаан дахь ТУЗ-ийн хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	2023 оны 5 дугаар сарын 04-12-ны өдөр. 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр. 2023 оны 6 дугаар сарын 02-07-ны өдөр. 2023 оны 6 дугаар сарын 09-16-ны өдөр
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал	Байхгүй	
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	Байхгүй	
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр/Ажиглагчаар	2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр

ТУЗ-ийн хурлууд

- Тайлант хугацаанд **ТУЗ-ийн ээлжит хурал** хуралдаагүй болно.
- **ТУЗ-ийн ээлжит бус хурал** [2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр]-ийн өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:
 1. ТУЗ-ийн Хараат бус гишүүн Эрик Версавелийг өөрийн хүсэлтээр чөлөөлөх тухай; мөн
 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр зарлах тухай.

Хэлэцсэн асуудал 1:

Миний зүгээс ТУЗ-ийн гишүүн (Хараат бус гишүүн/Хувьцаа эзэмшигч/Гүйцэтгэх удирдлага) нь банкинд орж ажиллахаасаа өмнө банкны нэр хүндэд эрсдэл учруулж болзошгүй олон нийтэд ил гарсан (бичсэн ном/танилцуулга/ярилцлага зэрэг хамаарах ба зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй) зүйлсийг ил тод мэдээлэх ёстой гэсэн саналыг хэлсэн. Хэрэв ТУЗ-д орсны дараа ижил үр дүнд хүргэж болзошгүй үйлдэл хийхээр төлөвлөж байгаа бол уг үйлдлийг эхлүүлэхээс өмнө ТУЗ-д мэдэгдэх ёстой.

- Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах **цахим санал хураалтын** хурлуудад оролцсон.

Хамрах хугацаан дахь цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурлууд	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Эх үүсвэр татах санхүүжилтийн төлөвлөгөөг батлах тухай.	2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрөөс 12-ны өдөр.
	2023 оны шинэчилсэн тогтворжуулах төлөвлөгөөг батлах тухай.	2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 07-ны өдөр
	М**-д зээлийн шугам нээх асуудлыг батлах (сонирхлын зөрчилтэй хэлцэл).	2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс 16-ны өдөр
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны цахим санал хураалтын хурал	Байхгүй	
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны цахим санал хураалтын хурал	Байхгүй	

Эх үүсвэр татах санхүүжилтийн төлөвлөгөөний тухайд, энэ нь 2023 оны ХасБанкны цэвэр хүүгийн маржинд хэрхэн нөлөөлөх талаар асуусан. Тус асуултад Санхүү хариуцсан Захирал ХасБанк 2023 онд цэвэр хүүгийн маржинг 7 орчим хувьд барихаар тооцоолсон гэж хариулсан. Би тус асуудлыг дэмжсэн.

2023 оны шинэчилсэн тогтворжуулах төлөвлөгөөг батлах тухай асуудалд, эдийн засгийн хямралын үед стрессийн хувилбаруудыг өөрчилж буй үндэслэлийг асуусан. Тодруулбал, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 6%-иас 7% хүртэл буурч, ажилгүйдлийн түвшин 18% биш 20% болж байгаа шалтгааныг асуусан. Эрсдэлийн удирдлагын хорооны Нарийн бичгийн дарга тус асуултад макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг илүү хүнд нөхцөлөөр буюу ДНБ 7%-иар бууруулж, ажилгүйдлийн түвшинг 20%-иар таамагласан гэж хариулсан. Би шинэчилсэн тогтворжуулах төлөвлөгөө батлах асуудлыг дэмжсэн.

М**-д зээлийн шугам нээх асуудлыг батлах (сонирхлын зөрчилтэй хэлцэл) тухай асуудалд, 3 жилийн борлуулалтын төсөөллийн талаар нэмэлт мэдээлэл асуусан. Үүнд: цахилгаан тээврийн хэрэгсэл (EV)-ийн зах зээл дэх эзлэх хувь болон цаашид Тесла цахилгаан тээврийн хэрэгсэл Монголын зах зээлд орж ирнэ гэж үзвэл тус борлуулалтын төсөөлөлд үзүүлэх нөлөөллийн талаар

асуусан. Эрсдэлийн удирдлагын хорооны нарийн бичгийн дарга үүнд хариулж, цахилгаан тээврийн хэрэгслийн зах зээлийн дүн шинжилгээний талаар мэдээллийг өгсөн. Мөн Тесла ойрын 3 жилд Монголын зах зээлд гарах магадлал бага байгаа тул борлуулалтад үзүүлэх нөлөөлөл байхгүй гэж хариулсан. Үүний дараа миний зүгээс тус хэлцлийг батлахыг дэмжсэн.

Миний зүгээс дээрх 3 хэлэлцсэн асуудал, хэлэлцүүлгэд санал нийлээгүй зүйл байхгүй байсан ба шийдвэр гаргуулахаар санал болгосон 3 асуудлыг дэмжсэн.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурлаар 1 (нэг) сонирхлын зөрчилтэй хэлцэл батлагдсан бөгөөд эдгээр бүх хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалын талаар миний ажиглалт: Хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд тодорхой үүрэг, хариуцлага байдаг. Хамрах хугацаанд гаргасан бүх шийдвэрүүд Банкны эрх ашиг, сонирхолд нийцэж гарсан.

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ

КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, нарийн зүйлүүдийг анхаарч авч үздэгийг ажигласан. Ялангуяа хатуу хуваарьтай байсан ч хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) үйл явцад бүх хүчин чармайлтаа гаргасан.
КтХ 79.3.2	Хамаарахгүй/Ажиглагдаагүй

(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	
КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГУУЛАХ)	<p>[2023 оны 4 дүгээр сарын 27]-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ажиглагчаар оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан.</p> <p>[2023 оны 6 дугаар сарын 12]-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулах, тодруулга хийхэд бэлэн байсан.</p>
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, нарийн зүйлүүдийг анхаарч авч үздэгийг ажигласан. Ялангуяа хатуу хуваарьтай байсан ч хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) үйл явцад бүх хүчин чармайлтаа гаргасан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын баг бүх цаг үед холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг хичээж байсныг ажигласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	Хамаарахгүй/Ажиглагдаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Хамаарахгүй/Ажиглагдаагүй.

4. БУСАД

Хамаарахгүй.

Огноо: 2023.07.03

Тайлан гаргасан: Эми Чой, ТУЗ-ийн Хараат бус гишүүн